# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
# ТОГТООЛ

2023 оны 05 сарын 31 өдөр Дугаар 213 Улаанбаатар хот

**Цалингийн хэмжээ тогтоох итгэлцүүр,
түүнийг хэрэглэх төрийн байгууллагын
жагсаалт, орон тооны дээд хязгаар
тогтоох тухай**

Төрийн албаны тухай хуулийн 57.15, 57.16 дахь хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Төрийн албанд ажиллах мэдээлэл технологийн чиглэлээр нарийн мэргэшсэн, өндөр ур чадвар бүхий ажилтны албан тушаалын цалингийн хэмжээг тогтоох итгэлцүүр”-ийг 1 дүгээр хавсралт, “Мэдээлэл технологийн чиглэлээр нарийн мэргэшсэн, өндөр ур чадвар бүхий ажилтан ажиллуулах төрийн байгууллагын жагсаалт, мэдээлэл технологийн чиглэлээр ажиллах ажилтны орон тооны дээд хязгаар”-ыг 2 дугаар хавсралт ёсоор тус тус батлагсугай.

2.Энэ тогтоол гарсантай холбогдуулан шаардагдах зардлыг батлагдсан орон тоо, төсөвтөө багтаан шийдвэрлэхийг Төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Л.ОЮУН-ЭРДЭНЭ

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД Х.БУЛГАНТУЯА

Засгийн газрын 2023 оны 05 дугаар
сарын 31 -ний өдрийн 213 дугаар
тогтоолын 2 дугаар хавсралт

# МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ЧИГЛЭЛЭЭР НАРИЙН МЭРГЭШСЭН, ӨНДӨР УР ЧАДВАР БҮХИЙ АЖИЛТАН АЖИЛЛУУЛАХ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЖАГСААЛТ, МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ЧИГЛЭЛЭЭР АЖИЛЛАХ АЖИЛТНЫ ОРОН ТООНЫ ДЭЭД ХЯЗГААР

| № | Төрийн байгууллагын нэр | Албан тушаалын төрөл | |
|---|---|---|---|
| | | Гүйцэтгэх | Туслах |
| 1. | Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар | 1 | 1 |
| 2. | Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын алба | 1 | - |
| 3. | Монгол Улсын Их Хурлын Тамгын газар | 1 | 1 |
| 4. | Шүүхийн ерөнхий зөвлөл | 2 | - |
| 5. | Монгол Улсын дээд шүүхийн Тамгын газар | 3 | - |
| 6. | Монгол Улсын ерөнхий прокурорын газар | 2 | - |
| 7. | Шүүхийн сахилгын хороо | 1 | 1 |
| 8. | Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газар | 1 | 1 |
| 9. | Эдийн засаг, хөгжлийн яам | 1 | 1 |
| 10. | Гадаад харилцааны яам | 1 | 1 |
| 11. | Сангийн яам | 1 | 1 |
| 12. | Хууль зүй, дотоод хэргийн яам | 2 | 2 |
| 13. | Байгаль орчин, аялал жуулчлалын яам | 1 | 1 |
| 14. | Батлан хамгаалах яам | 1 | 1 |
| 15. | Барилга, хот байгуулалтын яам | 1 | 1 |
| 16. | Боловсрол, шинжлэх ухааны яам | 1 | 1 |
| 17. | Зам, тээврийн хөгжлийн яам | 3 | 2 |
| 18. | Соёлын яам | 1 | 1 |
| 19. | Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам | 1 | 1 |
| 20. | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам | 1 | 1 |
| 21. | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам | 1 | 1 |
| 22. | Цахим хөгжил, харилцаа холбооны яам | 2 | 3 |
| 23. | Эрчим хүчний яам | 2 | 1 |
| 24. | Эрүүл мэндийн яам | 1 | 2 |
| 25. | Хүний эрхийн үндэсний комисс | 1 | - |
| 26. | Төрийн албаны зөвлөл | 2 | - |
| 27. | Үндэсний аудитын газар | 2 | 1 |
| 28. | Үндэсний статистикийн хороо | 2 | 2 |
| 29. | Сонгуулийн ерөнхий хороо | 2 | - |

| | | | |
|---|---|---|---|
| 72. | Нийслэлийн Цахим хөгжил, мэдээллийн технологийн газар | 1 | 1 |
| 73. | Дүүргийн Засаг даргын Тамгын газар (тус бүр) | - | 1 |

----о0о----